

## **МОНГОЛЫН ХҮН АМЫН ХООЛ ТЭЖЭЭЛИЙН БАЙДАЛ - ҮНДЭСНИЙ IV СУДАЛГАА**

### **Судалгааны зорилго:**

Монгол улсын хүн амын хоол тэжээлийн өнөөгийн байдалд үнэлгээ өгөх, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний чиг хандлага, саналыг боловсруулахад судалгааны зорилго оршино.

### **Судалгааны зорилт:**

1. Бага насны хүүхдийн хооллолтын байдлыг үнэлж, тэдний дундах уураг илчлэг болон бичил тэжээлийн дутал (цус багадалт, төмөр, А болон Д аминдэмийн дутал)-ын тархалтын түвшинг тогтоох;
2. Төрөх насны (15-49) эмэгтэйчүүдийн хоол тэжээл, баяжуулсан хүнсний талаарх мэдлэг, хооллолт, бичил тэжээлийн хангамжийн байдалд үнэлгээ өгч, цус багадалт, төмөр, Д аминдэм дутлын тархалтын түвшинг тогтоох;
3. Жирэмсэн эмэгтэйчүүдийн цус багадалт, иод дутлын эмгэгийн тархалтын түвшинг тогтоох;
4. Сургуулийн насны хүүхдийн дунд иод дутлын эмгэгийн тархалтын түвшинг тогтоох;
5. Өрхийн иоджуулсан давс, баяжуулсан гурилын хэрэглээний өнөөгийн байдалд үнэлгээ өгөх;
6. Монголын 15-49 насны хүн ам, жирэмсэн эмэгтэйчүүдийн давсны хоногийн хэрэглээний өнөөгийн түвшинг тогтоох,
7. Хүн амын хоол тэжээлийн байдлыг сайжруулах чиглэлээр цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний чиг хандлагыг тодорхойлох

### **Судалгааны шинэлэг тал**

Тархвар зүйн судалгааны орчин үеийн аргуудыг хослуулан ашиглаж, үр дүнд үндэслэн үндэсний төдийгүй эдийн засгийн 4 бүс, Улаанбаатар хотын түвшинд зорилтот бүлгийн хүн амын хоол тэжээлийн байдалд үнэлгээ өгч байгаад энэ судалгааны шинэлэг тал оршино.

### **Судалгааны хязгаарлагдмал тал**

Хоол тэжээлийн үндэсний IV судалгаа нь нэг агшинд хийгддэг тархвар зүйн судалгаануудын адил зарим хязгаарлагдмал талтай билээ. Судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг зөвхөн дулааны улиралд хийсэн тул үр дүнд нь улирлын хамаарлыг тусгах боломжгүй байна. Судалгаанд зөвхөн 5 хүртэлх болон 7-11 насны хүүхэд хамрагдсан тул судалгааны үр дүн бусад насны хүүхдийн хоол тэжээлийн байдлыг илтгэхгүй. Орон нутгийн захиргааны хүн амын бүртгэлийг ашиглан судалгааны түүвэрлэлт хийсэн тул бүргэлгүй өрхүүд судалгаанд хамрагдах боломж хязгаарлагдмал байсан.

## **ҮР ДҮН, ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ**

### **БАГА НАСНЫ ХҮҮХЭД**

1. Төрөөд 1 цагийн дотор ангир уургаа амласан болон эхийн сүүгээр дагнан хооллож буй хүүхдийн эзлэх хувь 2004 оны түвшингээс нэмэгдсэн байна. Хоёр хүртэлх насны хүүхдийн дийлэнх нь насандаа тохирсон давтамжтай хооллож байгаа боловч хоногт хэрэглэж буй хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл цөөн байгаа нь тухайн насны хүүхдийн хоол тэжээлийн хэрэгцээг бүрэн хангах боломжгүй байна.
2. Монголын бага насны хүүхдийн дундах өсөлт хоцролтын тархалт буурсан боловч рахит, цус багадалт зэрэг бичил тэжээлийн дуталтай хүүхдийн эзлэх хувь 2004 оны түвшингээс буураагүй байна. Тав хүртэлх насны тураалтай хүүхдийн эзлэх хувь тогтвортой буурч, МУ Мянганы хөгжлийн I зорилтыг хангасан болохыг баталж байна.
3. Бага насны хүүхдийн дундах хоол тэжээлийн дутлын тархалт бүс нутгийн түвшинд харилцан адилгүй байгаа тул орон нутгийн өвөрмөц шаардлагад нийцсэн зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

4. Хоол тэжээлийн дутлын тархалт хүүхдийн наснаас хамаарч харилцан адилгүй, ялангуяа 2 хүртэлх насны хүүхдийн дунд нилээд түгээмэл байгаа нь тухайн насны хүүхдийн хоол тэжээлийн дутлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээг тогтвортой хэрэгжүүлэх шаардлагатайг илтгэж байна.

5. Бага насны хүүхдийг аминдэм, эрдсийн бэлдмэл (А, Д аминдэм, төмрийн бэлдмэл, ОНБТХ)-ээр хангах, “Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-ийг хөтлөх тухай ЭМ-ийн Сайдын тушаалын хэрэгжилт хангалтгүй байгаа тул санхүүгийн тогтвортой эх үүсвэрийг шийдвэрлэх замаар бэлдмэл, “Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-ийн хангамжийг сайжруулах, улмаар түгээлт, бүртгэл мэдээлэл, хяналт үнэлгээг эрчимжүүлэх шаардлагатай байна.

6. Эхчүүд, асран хамгаалагчдын хүүхдийн зохистой хооллолтын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, бага насны хүүхдийг хооллох зөв дадал төлөвшүүлэх мэдээлэл, сургалт сурталчилгааг өргөжүүлэх, эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэгчдийн уг асуудлаар зөвлөгөө өгөх ур чадварыг сайжруулах шаардлагатай байна.

### **СУРГУУЛИЙН 7 – 11 НАСНЫ ХҮҮХЭД**

1. Сургуулийн 7–11 насны 10 хүүхэд тутмын нэг нь өсөлт хоцролттой, өсөлт хоцролтын тархалт хөдөөгийн хүүхдийн дунд өндөр байна.

2. Сургуулийн хүүхдийн нэг удаагийн шээсэн дэх иодын дундаж голч хэмжээ 171.2 мкг/л буюу ДЭМБ – аас зөвлөсөн лавлагаа хязгаарт байгаа бөгөөд бахлуурын тархалт 1995 оны түвшингээс 4 дахин буурсан нь ИДЭТ үндэсний хөтөлбөр амжилттай хэрэгжсэнийг илтгэж байна.

3. Сургуулийн 7-11 насны хүүхдийн ИДЭ, Иоджуулсан давсны талаарх мэдлийг түвшин 2007 оны түвшингээс буурсан байгаа тул эрүүл мэндийн хичээлийн сургалтын чанарт анхаарал хандуулах нь зүйтэй байна.

### **ЖИРЭМСЭН ЭМЭГТЭЙ**

1. Өсвөр насны жирэмсэн эмэгтэйчүүдийн дундах туранхай хүний эзлэх (5.8%) хувь өндөр байгаа тул энэ насны эмэгтэйчүүдэд чиглэсэн мэдээлэл, сургалт сурталчилгааг сайжруулах шаардлагатай байна.

2. Үндэсний түвшинд жирэмсэн эмэгтэйчүүдийн дундах цус багадалтын тархалт “дунд” зэрэг байгаа боловч зарим бүс нутагт өндөр, жирэмсний хугацаа, боловсролын түвшингээр ялгаатай байгааг хэрэгжүүлж буй арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулахад харгалзан үзэх шаардлагатай байна.

3. Жирэмсэн эмэгтэйчүүдийг бичил тэжээлийн дутлаас сэргийлэх зорилготой төмрийн бэлдмэл, ялангуяа ОНБТБ-ийг зохих тунгаар хангах арга хэмжээний хамралт, бэлдмэлийн түгээлт хангалтгүй байгаа тул ЭМ-ын Сайдын тушаалын хэрэгжилтийг эрчимжүүлэх нь зүйтэй.

4. Баруун, хангай, зүүн бүсийн жирэмсэн эмэгтэйчүүд иодын дуталд өртөх эрсдэлтэй байгааг харгалзан тухайн орон нутагт иоджуулсан давсны хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай байна.

### **ТӨРӨХ НАСНЫ ЭМЭГТЭЙ**

1. МУ-ын 15–49 насны гурван эмэгтэй тутмын нэг нь илүүдэл жин эсвэл таргалалттай, таргалалтын тархалт нас ахих тутам нэмэгдэх хандлагатай байгаа тул энэ насны эмэгтэйчүүдийн дунд халдварт бус өвчин, түүний эрсдэлт хүчин зүйлсээс сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай байна.

2. Цус багадалтгүй эмэгтэйчүүдийн дунд төмөр дутлын тархалт өссөн нь цус багадалтын тархалтад нөлөөлж байгааг онцгой анхаарч, чиглэсэн арга хэмжээ авах нь зүйтэй.

3. Зүүн бүсийн эмэгтэйчүүд Д аминдэм дуталд харьцангуй их өртөж байгаа тул тухайн орон нутагт чиглэсэн зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

4. Баяжуулсан хүнс, ялангуяа баяжуулсан гурилын талаарх төрөх насны эмэгтэйчүүдийн мэдлэг хангалтгүй байгаа тул тэдний баяжуулсан хүнс, ялангуяа баяжуулсан гурилын ач

холбогдлын талаарх мэдээлэл, сургалт сурталт сурталчилгааны хүрээг өргөжүүлэх шаардлагатай байна.

### **15 – 49 НАСНЫ ЭРЭГТЭЙ**

1. 15 – 49 насны дөрвөн эрэгтэй тутмын нэг нь илүүдэл жин эсвэл таргалалттай, 15-49 насны туранхай эрэгтэйчүүдийн эзлэх хувь харьцангуй өндөр байгаа тул эрэгтэйчүүдийн дунд тохиолдож буй хоол тэжээлийн илүүдэл ба дутлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.
2. Гэр бүл төлөвлөлт, жирэмслэлтэд бэлтгэх асуудлаар эрэгтэйчүүдийн мэдлэгийн түвшин нас ахих тутам нэмэгдэх хандлагатай, зүүн бүсийн эрэгтэйчүүдийн мэдлэг бусад бүстэй харьцуулахад доогуур байгааг үндэслэн тэдний мэдлэгийг сайжруулах, орон нутгийн онцлогт тохирсон арга хэмжээг хэрэгжүүлэх нь зүйтэй.

### **БАЯЖУУЛСАН ХҮНСНИЙ ХЭРЭГЛЭЭ**

1. МУ-ын нийт өрхийн иоджуулсан давсны хэрэглээ ба иоджуулсан давсны талаарх хүн амын ойлголт харьцангуй өндөр хувьтай байгаа тул цаашид уг үзүүлэлтийг бууруулахгүй байх, тогтвортой хадгалах талаар анхаарч ажиллах хэрэгтэй.
2. Иоджуулсан давсны иодын дундаж агууламж 24.8 мг/кг буюу ДЭМБ-ын зөвлөмж хязгаарт байгаа ба цаашид иоджуулсан давсны дотоод ба хөндлөнгийн чанарын хяналтыг тогтмолжуулах хэрэгтэй байна.
3. Шийдвэр гаргагч нарт бичил тэжээлийн дутлыг бууруулахад баяжуулсан хүнсний ач холбогдлын талаар ухуулан таниулах, сургалт зохион байгуулах, нийт хүн амын баяжуулсан хүнс, ялангуяа баяжуулсан гурилын хэрэглээг дэмжихэд олон нийтийн хэвлэл мэдээлийн хэрэгслийг өргөнөөр ашиглах шаардлагатай байна.

### **ДАВСНЫ ХЭРЭГЛЭЭ**

1. МУ-ын жирэмсэн ба төрөх насны эмэгтэйчүүд, 15-49 насны эрэгтэйчүүдийн давсны хоногийн дундаж хэрэглээ ДЭМБ-ын зөвлөмж хэмжээнээс гурав дахин өндөр байна.
2. Давсыг хэтрүүлэн хэрэглэхийн хор хөнөөл, хоол хүнсээр авах давсны эх сурвалжийн талаар олон нийтэд зориулсан сурталчилгааны материал боловсруулж түгээх, давсны хэрэглээг бууруулах, зөвхөн иоджуулсан давсны хэрэглээг дэмжихэд хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглах шаардлагатай.